



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Өгийнуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/105/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Грут финанс Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж Утас: 77721628 Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.24 № 57

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН
ӨГИЙНУУР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Э.ДОРЖХАНД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Өгийнуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,748,343.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 2,581,455.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 үндсэн зорилтын хүрээнд 90 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	349,965,863.22	245,298,961.73
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	177,181,651.49	103,403,018.46
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	177,181,651.49	103,403,018.46
3121	Төгрөг	177,181,651.49	103,403,018.46
31211	Төрийн сангийн харилцах	177,181,651.49	103,403,018.46
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	172,784,211.73	141,895,943.27
351	Түүхий эд материал	17,443,918.00	18,763,555.00
35110	Тусгай зориулалттай материал	17,443,918.00	18,763,555.00
354	Хангамжийн материал	155,340,293.73	123,132,388.27
35410	Бичиг хэргийн материал	1,186,085.00	645,525.00
35420	Аж ахуйн материал	154,154,208.73	122,486,863.27
346	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,960,767,676.70	3,652,477,551.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,960,767,676.70	3,652,477,551.31
392	Биет хөрөнгө	1,904,251,486.70	3,597,682,021.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,896,977,322.00	3,506,736,077.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(311,216,900.36)	(298,860,973.32)
39203	Авто тээврийн хэрэгсэл	10,500,000.00	10,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,500,000.00)	0.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	334,440,100.00	340,325,590.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(137,021,609.31)	(156,517,441.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	110,297,140.40	162,043,425.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(43,113,365.30)	(41,008,856.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,315,200.00	20,315,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,419,519.96)	(665,706.60)
39217	Ном	52,993,119.23	54,814,707.23
393	Биет бус хөрөнгө	56,516,190.00	54,795,530.00
39301	Програм хангамж	8,853,300.00	8,603,300.00
39302	Хасагдуулга	(1,545,110.00)	(3,015,770.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	49,208,000.00	49,208,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,310,733,539.92	3,897,776,513.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	3,877,700.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	3,877,700.00
413	Өглөг	0.00	3,877,700.00
4136	Бусад өглөг	0.00	3,877,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	3,877,700.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,310,733,539.92	3,893,898,813.04
51	Засгийн газрын хувь оролцоо	2,310,733,539.92	3,893,898,813.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,048,175,797.68	2,048,175,797.68
51101	Өмч: - төрийн	2,048,175,797.68	2,048,175,797.68
512	Хуримтлагдсан үр дүн	(13,689,929.37)	1,631,252,900.75
51210	Өмнөх үеийн үр дүн	(13,689,929.37)	48,087,627.63
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	1,583,165,273.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	276,247,671.61	214,470,114.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,310,733,539.92	3,897,776,513.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Архангай аймгийн Өгийнуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,282,231,008.00	4,308,577,464.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	104,358,608.00	1,786,786,164.00
120	Нийтлэг татварын бус орлого	104,358,608.00	1,786,786,164.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,156,509.00	87,084,234.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,168,500.00	2,867,710.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,050,000.00	415,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,938,009.00	83,801,524.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- үндсэн хөрөнгө	90,000,025.00	1,698,043,878.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	7,202,074.00	1,658,052.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,177,872,400.00	2,521,791,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,967,809,600.00	2,251,775,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,967,809,600.00	2,251,775,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	210,062,800.00	270,015,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	210,062,800.00	270,015,600.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,218,583,373.19	2,725,412,190.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,218,583,373.19	2,725,412,190.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,143,050,139.55	2,617,003,554.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,493,379,283.00	1,843,007,255.21
210101	Цалин	922,952,018.00	1,123,207,936.65
210102	Нэмэгдэл цалин	504,697,815.00	618,026,978.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6,211,409.00
210104	Урамшуулал	65,729,450.00	95,560,931.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,790,420.67	226,174,711.03
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	125,789,460.73	156,002,862.25
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	15,025,623.16	18,406,683.55
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	7,776,102.75	9,313,857.67
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	7,086,514.23	8,462,366.67
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	28,112,719.80	33,988,940.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	201,963,766.36	232,617,923.88
210301	Гэрэл цахилгааны зардал	11,200,496.88	16,223,537.60
210302	Түлш, халаалтын зардал	190,025,669.48	215,056,970.28
210303	Цэвэр, бохир усны зардал	737,600.00	1,337,416.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	36,281,730.46
210408	Бараа материал акталсны зардал	-	36,281,730.46
2105	Нормативт зардал	51,670,654.00	66,467,300.00
210502	Хоол, хүнс	51,670,654.00	66,467,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,800,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	3,800,000.00	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	19,465,850.70	29,685,811.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,288,500.00	2,867,700.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	15,177,350.70	26,818,111.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,980,164.82	176,768,822.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,414,824.23	31,025,795.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	14,941,300.00	14,037,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,624,040.59	131,705,127.39

**Архангай аймгийн Өгийнуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,533,233.64	108,408,636.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	71,234,200.00	91,010,960.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,997,700.00	82,988,760.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,236,500.00	8,022,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,299,033.64	17,397,676.12
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,299,033.64	17,397,676.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	63,647,634.81	1,583,165,273.12
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	63,647,634.81	1,583,165,273.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,183,090,900.00	2,525,074,010.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,218,500.00	3,282,710.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,218,500.00	3,282,710.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,218,500.00	3,282,710.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,168,500.00	2,867,710.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,050,000.00	415,000.00
120009	Бусад орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,177,872,400.00	2,521,791,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,967,809,600.00	2,251,775,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,967,809,600.00	2,251,775,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	210,062,800.00	270,015,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	210,062,800.00	270,015,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,095,395,522.60	2,557,283,043.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,095,395,522.60	2,557,283,043.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,019,862,288.96	2,448,874,406.91
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,493,379,283.00	1,843,007,255.21
210101	Үндсэн цалин	922,952,018.00	1,123,207,936.65
210102	Нэмэгдэл	504,697,815.00	618,026,978.56
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	6,211,409.00
210104	Урамшуулал	65,729,450.00	95,560,931.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,790,420.67	226,174,711.03
210201	Тэтгэврийн даатгал	125,789,460.73	156,002,862.25
210202	Тэтгэмжийн даатгал	15,025,623.16	18,406,683.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,776,102.75	9,313,857.67
210204	Ажилгүйдлийн даатгал	7,086,514.23	8,462,366.67
210205	Эрүүл мэндийн даатгал	28,112,719.80	33,988,940.89

Архангай аймгийн Өгийнуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	201,963,766.36	232,617,923.88
210301	Гэрэл, цахилгаан	11,200,496.88	16,223,537.60
210302	Түлш, халаалт	190,025,669.48	215,056,970.28
210303	Цэвэр, бохир ус	737,600.00	1,337,416.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	0.00	-
210502	Хоол, хүнс	0.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	-
210604	Урсгал засвар	0.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,908,294.00	66,467,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	51,908,294.00	66,467,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,800,000.00	6,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,800,000.00	6,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,465,850.70	29,685,811.79
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,288,500.00	2,867,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг -Орон нутгийн төсөв	0.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,177,350.70	26,818,111.79
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	-
	Дотоод эх үүсвэрээр	65,554,674.23	44,921,405.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,105,074.23	34,761,205.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	14,449,600.00	10,160,200.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	75,533,233.64	108,408,636.12
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	71,234,200.00	91,010,960.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	55,997,700.00	82,988,760.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Архангай аймгийн Өгийнуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,048,175,797.68	276,247,671.61	(77,337,564.18)	2,247,085,905.11
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,048,175,797.68	276,247,671.61	(77,337,564.18)	2,247,085,905.11
Тайлант үеийн үр дүн	-	-	63,647,634.81	63,647,634.81
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,048,175,797.68	276,247,671.61	(13,689,929.37)	2,310,733,539.92
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,048,175,797.68	276,247,671.61	(13,689,929.37)	2,310,733,539.92
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(61,777,557.00)	61,777,557.00	-
Тайлант үеийн үр дүн	-	-	1,583,165,273.12	1,583,165,273.12
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,048,175,797.68	214,470,114.61	1,631,252,900.75	3,893,898,813.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,748,343,000.00	2,581,454,966.91	166,888,033.09	93.9
УРСГАЛ ЗАРДАЛ	2,748,343,000.00	2,581,454,966.91	166,888,033.09	93.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,650,662,600.00	2,490,444,006.91	160,218,593.09	94.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,933,867,000.00	1,843,007,255.21	90,859,744.79	95.3
Үндсэн цалин	1,209,292,900.00	1,123,207,936.65	86,084,963.35	92.9
Нэмэгдэл	660,467,200.00	618,026,978.56	42,440,221.44	93.6
Унаа хоолны Хөнгөлөлт	-	6,211,409.00	(6,211,409.00)	-
Урамшуулал	64,106,900.00	95,560,931.00	(31,454,031.00)	149.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,733,300.00	226,174,711.03	15,558,588.97	93.6
Тэтгэврийн даатгал	164,378,700.00	156,002,862.25	8,375,837.75	94.9
Тэтгэмжийн даатгал	19,338,700.00	18,406,683.55	932,016.45	95.2
ҮОМШӨ-ний даатгал	9,669,300.00	9,313,857.67	355,442.33	96.3
Ажилгүйдлийн даатгал	9,669,300.00	8,462,366.67	1,206,933.33	87.5
Эрүүл мэндийн даатгал	38,677,300.00	33,988,940.89	4,688,359.11	87.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	250,015,600.00	232,617,923.88	17,397,676.12	93.0
Гэрэл, цахилгаан	17,504,600.00	16,223,537.60	1,281,062.40	92.7
Түлш, халаалт	230,719,000.00	215,056,970.28	15,662,029.72	93.2
Цэвэр, бохир ус	1,792,000.00	1,337,416.00	454,584.00	74.6
Хангамж, бараа материалын зардал	-	-	-	-
Нормативт зардал	101,453,600.00	66,467,300.00	34,986,300.00	65.5
Хоол, хүнс	101,453,600.00	66,467,300.00	34,986,300.00	65.5
Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
Урсгал засвар	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
Томиллолт, зочны зардал	-	-	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,407,400.00	29,685,811.79	721,588.21	97.6

Архангай аймгийн Өгийнуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,867,700.00	2,867,700.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,539,700.00	26,818,111.79	721,588.21	97.4
Бараа үйлчилгээний бусад зардал	73,185,700.00	72,491,005.00	694,695.00	99.1
Бараа үйлчилгээний бусад зардал	63,025,500.00	62,330,805.00	694,695.00	98.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	10,160,200.00	10,160,200.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,680,400.00	91,010,960.00	6,669,440.00	93.2
Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	-
Бусад урсгал шилжүүлэг	97,680,400.00	91,010,960.00	6,669,440.00	93.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,022,200.00	8,022,200.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,748,343,000.00	2,507,676,333.88	240,666,676.12	91.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,475,044,700.00	2,251,775,700.00	223,269,000.00	91.0
Улсын төсвөөс санхүүжих	2,302,408,600.00	2,251,775,700.00	50,632,900.00	97.8
Оны эхний үлдэгдлээс санхүүжих	172,636,100.00	-	172,636,100.00	-
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	270,015,600.00	252,617,923.88	17,397,676.12	93.6
Орон нутгийн төсвөөс	270,015,600.00	252,617,923.88	17,397,676.12	93.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,282,700.00	3,282,710.00	-	100.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,867,700.00	2,867,710.00	(10.00)	100.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	415,000.00	415,000.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	177,181,651.49	177,181,651.49	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	177,181,651.49	103,403,018.46	73,778,643.03	58.4
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
Төсвийн байгууллага	1	1		100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	60	60		100.0
Удирдах ажилтан	3	3		100.0
Гүйцэтгэх ажилтан	35	35		100.0
Үйлчлэх ажилтан	22	22		100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	555	555		100.0
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	555	555		100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 506.1 мянган төгрөгийн 1 алдаа илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

- "51300 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү" дансны эхний үлдэгдэл нь 276,247.7 мянган төгрөг бол үндсэн хөрөнгийн тайлан дахь дахин үнэлгээний нэмэгдлийн дүн 275,741.6 мянган төгрөг буюу 506.1 мянган төгрөгөөр дутуу байв.

Аудитаар залруулаагүй 6,483.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 1,122.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 5,361.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 6,483.5 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 29,533,6 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Цалин, нэмэгдэл урамшууллын зардлыг хянаж үзэхэд нэр бүхий 4 ажилтанд 1,122.2 мянган төгрөгийн цалин илүү тооцон олгожээ. Энэ нь цагийн бүртгэл буруу, цагийн бүртгэлээс зөрүүтэйгээр цалин бодсонтой холбоотой байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. "Балансын урамшуулал олгох тухай" Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, тус сургуулийн захирлын 2025.09.23-ны өдрийн Б/43 дугаар тушаалуудыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийн, няравт 1,105.0 мянган төгрөг нийт "балансын урамшуулал" 2,664.0 мянган төгрөгийг "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2.2. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо зөвхөн хувь хүний орлогын албан татвар 10 хувиар буюу 802.2 мянган төгрөг суутган 7,220.0 мянган төгрөгийг 56 ажилтанд олгохдоо суутган буюу ногдуулан төлөх 1,891.6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тайлагнаагүй байна..

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 “Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна”: 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2.3. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-т заасан хөнгөлөлтийг 12 ажилтанд 442.0 төгрөгөөр илүү эдлүүлснээс татварыг мөн дүнгээр дутуу, 26 ажилтанд 363.7 мянган төгрөгөөр дутуу эдлүүлснээс татварыг мөн дүнгээр илүү тайлагнажээ.

Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралт "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 4.4.1 "Тухайн тайлант жилийн 12 сард бүрэн тухайн байгууллагад харьяалагдаж ажилласан ажилтанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг мөн хуулийн 27.1-д заасны дагуу жилийн эцэст өссөн дүнгээр тооцож, зөрүүг залруулж тайлагнана", 4.4.2 "Тайлант жилийн 12 сарын турш тухайн байгууллагад харьяалагдаж ажиллаагүй ажилтныг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг суутгагч өссөн дүнгээр тооцох, зөрүүг залруулах үүрэг хүлээхгүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралт "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
	Залруулсан					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дахин үнэлгээний дүн зөрүүтэй	1	506.1	1	506.1	1	506.1
Нийт дүн	1	506.1	1	506.1	1	506.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү тооцож олгосон	1	1,122.2	1	1,122.2				
Балансын урамшуулал олгосон	1	2,664.0			1	2,664.0		
НДШ суутган буюу ногдуулаагүй.	1	1,891.6			1	1,891.6		
ХХОАТ буруу тайлагнасан	1	805.7			1	805.7		
Дүн	4	6,483.5	1	1,122.2	3	5,361.3		